

## ЖИЖИГ, ДУНД БИЗНЕСИЙН САНХҮҮЖИЛТИЙН БАЙДАЛД ХИЙСЭН СУДАЛГАА, ҮР ДҮН (Орхон аймгийн жишээн дээр)

Л.Баасандорж\*, Д.Мөнх-Эрдэнэ\*\*, Б.Батгэрэл\*\*\* ,

**Хураангуй:** Жижиг, дунд үйлдвэрлэл нь улс орнуудын эдийн засагт тэр дундаа хөгжиж буй орнуудын хөгжилд онцгой үүрэг гүйцэтгэдэг. Дэлхийн банкны судалгаанаас авч үзвэл жижиг, дунд үйлдвэрлэл нь хөгжиж буй улсуудын ажил эрхлэлтийн 40 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний 60 хүртэлх хувийг дангаар бүрдүүлдэг байна. (Монголбанк, 2018) Иймд жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарыг эрчимтэй дэмжиж, бодлогоор хөгжүүлэх нь ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулахын зэрэгцээ хүртээмжтэй эдийн засгийн осолтийг бүрдүүлэх гол тулгуур нь болж өгнө.

Мэдээллийн үнэ цэнд суурилсан өнөөгийн ертөнцөд судалгаанд суурилсан санал, зөвлөмжөөр төрийн бодлого боловсруулах нь нэн ач холбогдолтой билээ. Энэхүү судалгаагаар Орхон аймгийн жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилтийн нөхцөл байдлыг тодорхойлох түүвэр судалгаа авч, судалгааны үр дүнг нэгтгэн боловсрууллаа.

Энэхүү судалгааны ач холбогдол нь жижиг, дунд бизнесийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийн хэрэгцээ, өнөөгийн байдлыг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх санал зөвлөмж, дэмжлэгийг тодорхойлох явдал бөгөөд энэ хүрээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийн санхүүжилт авахтай холбоотой үүсэж буй хүндрэл, бэрхшээлийг тодорхойлж цаашид санхүүжилт авах хэрэгцээ, хүсэж буй зээлийн үндсэн нөхцөлийн талаар судалсан болно.

**Түлхүүр үгс:** зээл, жижиг дунд бизнес эрхлэгч, санхүүжилтийн хэрэгцээ, эх үүсвэр, хөрөнгө, бизнесийн салбар

## RESEARCH ON EFFICIENCY IN FINANCING OF SMALL AND MEDIUM SIZED BUSINESSES (on the example of orkhon province)

**Abstract:** Small and medium business plays a special role in the economy of any country, especially in the development of developing countries. According to world bank research, small and medium-sized businesses alone account for 40 percent of employment and up to 60 percent of gross domestic product (GDP) in developing countries. Encouraging and developing the small and medium business sector will increase employment, reduce poverty and become the main basis for economic growth.

In today's information-based world, it is very important to develop government policies based on research. In this article, we took a sample survey to determine the financing situation of small and medium-sized businesses in Orkhon province and aimed to present the results of the survey.

The significance of this study is to determine the current state of financing needed for small and medium-sized businesses, and provide suggestions and support for further implementation. We also studied the difficulties in obtaining financing for small and medium-sized businesses, their future financing needs, and the basic terms of loans.

**Keywords:** Loan, small and medium business-owner, financing needs, resource, capital, business sector

\* МУИС, Бизнесийн сургууль. (E-mail): [baasandorj@erdenetis.edu.mn](mailto:baasandorj@erdenetis.edu.mn)

\*\* “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль. (E-mail): [p.ac22e532@erdenetis.edu.mn](mailto:p.ac22e532@erdenetis.edu.mn)

\*\*\* “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх, ШУТИС-ийн харьяа Эрдэнэт цогцолбор дээд сургууль. (E-mail): [batgerel@erdenetis.edu.mn](mailto:batgerel@erdenetis.edu.mn)

**Удиртгал хэсэг:** Жижиг дунд үйлдвэрлэл нь хөгжиж буй орнуудын бизнес эрхлэгчдийн дийлэнх хувийг бүрдүүлж, тухайн улс орнуудын эдийн засгийн өсөлтөд тодорхой хувь нэмрээ оруулсаар ирсэн. Женев дэх Олон улсын Худалдааны Төв (International Trade Centre)-өөс дэлхийн улс орнуудын жижиг дунд үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварын үзүүлэлтийг тайлагнадаг (International Trade Centre, 2020, 2021, 2022) бол манай улсын хувьд Монгол банкнаас 2011 оноос хойш жил бүр жижиг дунд үйлдвэрлэлийн нөхцөл байдал, санхүүжилтийн байдлыг тодорхойлох түүвэр судалгааг улсын дүнгээр зохион байгуулж ирсэн. (Монголбанк, 2021) Харин аймгуудын түвшинд судалгааны түүвэрт хамрагдах замаар улсын дүнгээр нэгтгэгдсэн судалгаанд хамрагддагаас тусдаа хийгдэж нэгтгэгдсэн судалгааны үр дүн, тайлан байдаггүй. Иймээс бид энэхүү судалгааны ажлаар Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй жижиг дунд бизнесийн хөгжил, үйл ажиллагааны өнөөгийн байдал, санхүүжилт, тулгарч буй саад бэрхшээлийг тодорхойлж, бодлогын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх мэдээллийг гаргахыг зорилоо. Бид санал асуулга авах зорилтот бүлгээр жижиг, дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжийн эзэн/ гүйцэтгэх удирдлага (захирал, гүйцэтгэх, ерөнхий менежер, нягтлан гэх мэт) болон хувиараа хөдөлмөр эрхлэгч нарыг сонгосон ба судалгааг тоон болон чанарын судалгааны аргаар хийж, энгийн санамсаргүй түүврийн арга ашигласан. Түүврийн эх олонлогийг Үндэсний Статистикийн хорооны албан ёсны статистик мэдээллээс Орхон аймагт үйл ажиллагаа явуулж буй бизнес регистрийн санд бүртгэлтэй 2113 аж ахуйн нэгжээс түүврийн хамгийн бага оновчтой хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай,  $\pm 8\%$ -ийн алдааны хязгаартай байхаар тооцоолсон бөгөөд оновчтой түүврийн хэмжээ 140 гэж гарсан ба үүн дээр хувиараа бизнес эрхлэгч 34 түүврийн нэгжийг санамсаргүй байдлаар сонгон нэмж, нийт 174 нэгжээс судалгаа авсан. Түүвэр судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн мэдээллийг Орхон аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс авч ашигласан. Судалгааны мэдээллийн санг санал асуулга явуулах замаар цуглуулсан бөгөөд судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнесийн удирдлага, холбогдох албан тушаалтнаас ярилцлагын аргаар мэдээлэл авсан. Судалгааны санал асуулгыг Монгол банк (Монголбанк, 2018)-аас боловсруулсан жишиг санал асуулгын агуулгаар зохион байгуулж боловсруулсан ба зээлийн хүү, зээлийн хугацаа, зээлийн хэмжээ, зээлийн барьцаа хөрөнгө, зээлийн хураамж, шимтгэл, зээлийн батлан даалтын тогтолцоо зэрэг 6 үзүүлэлт танай компанийн сүүлийн 1 жилийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлснийг маш сайн (5), сайн (4), боломжийн (3), муу (2), маш муу (1), мэдэхгүй (0) гэсэн чанарын болон тоон үнэлгээгээр үнэлсэн болно.

**Үндсэн хэсэг:** Бид судалгааны эхний алхмаар жижиг, дунд бизнес эрхлэлттэй холбоотой санхүүжилтийн орчны хүчин зүйлийн нөлөөг тодорхойлж, үүний дараагийн алхмаар жижиг, дунд бизнесийн санхүүжилтийн байдлыг судалсан болно.

АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг, BEST хөтөлбөр, Хөгжлийн шийдэл ТББ-ын хамтарсан 2024 оны жижиг дунд бизнесийн өрсөлдөх чадварын судалгаа (USAID, 2024) -гаар компаниудын өрсөлдөх чадварыг үнэлэхдээ бизнес төлөвлөлт санхүүгийн боломжид хүрэх чадварыг компанийн чадавхыг тооцох нэг үзүүлэлт болгон үнэлсэн бөгөөд ингэхдээ өрсөлдөх чадварын матрицан үнэлгээний арга ашигласан ба бодлогын оновчлолыг шинжилгээг пиналти ботэлик (penalty for bottleneck) аргаар үнэлсэн байна. Уг судалгаагаар санхүүгийн боломжит эх үүсвэрийн индикатор хүчтэй түвшинд үнэлэгдсэн ба санхүүгийн зайлшгүй хэрэгцээгээ ямар эх үүсвэрээс шийдэх боломжоор үнэлсэн байна. Түүнчлэн орон нутгийн жижиг, дунд бизнесүүд Улаанбаатар хотынхоос санхүүжилтэд хүрэх боломж өндөр байгааг судалгааны үр дүн харуулсан байна.

Жижиг, дунд бизнес эрхлэгч, үйлдвэрлэгчид санхүүгийн боломжит эх үүсвэрийг өөрийн хөрөнгө, банкны зээл, ЖДҮ-г дэмжих сангийн зээл, бусад хөнгөлөлттэй зээл зэрэг эрсдэл багатай эх үүсвэрээс 80.4%-ийг, ББСБ-ын зээл, ханган нийлүүлэгчийн бартер, зээл, урьдчилгаа, хувь хүн бусад эх үүсвэрийн зээл, тодорхой эх үүсвэргүй эх сурвалж зэрэг эрсдэлтэй эх үүсвэрээр үлдэх 19.6%-ийг бүрдүүлж байгаа судалгааны үр дүн харуулсан байна. (USAID, 2024) Гэхдээ уг судалгаагаар санхүүжүүлж буй зээл, эх үүсвэрт тавигдах санхүүжилтийн орчны нарийвчилсан шалгуур үзүүлэлтүүдийг анхаарч судлаагүй байна. Бид энэ судалгаагаараа жижиг, дунд бизнес эрхлэхэд саад учруулж болзошгүй санхүүжилтийн орчны хүчин зүйлсийг зээлийн хүү, зээлийн хугацаа, зээлийн хэмжээ, зээлийн барьцаа хөрөнгө, зээлийн шимтгэл хураамж, зээлийн батлан даалтын тогтолцоо гэсэн зургаан үзүүлэлтээр тооцож, үзүүлэлт тус бүрээр индексийг гаргалаа. Бүлгийн индексийг тооцохдоо санхүүжилтийн орчны зүгээс бизнесийн үйл ажиллагаанд хүндрэл учруулж буй дээрх зургаан хүчин зүйлийн чанарын хариултыг тоон утгад шилжүүлэх замаар тооцоолж гаргасан болно.

Зураг 1. Зээлийн орчин




Санхүүжилтийн орчны индексийг үзүүлэлтүүдээр нь авч үзвэл зээлийн шимтгэл хураамж болон зээлийн хүү жижиг, дунд бизнес эрхлэгчдэд харьцангуй их хүндрэлтэй байдаг гэж хариулжээ. Бусад үзүүлэлтүүдийн хувьд ойролцоо үр дүнд гарсан буюу жижиг, дунд бизнес эрхлэгчдэд тодорхой хэмжээний хүндрэлтэй байдаг гэж хариулсан байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн эх үүсвэр дутагдах, санхүүжилтийн гэнэтийн болон байнгын хэрэгцээ гарах тохиолдол түгээмэл байдаг ба ихэнх бизнес эрхлэгчид санхүүжилтийн эх үүсвэрээ шийдвэрлэхдээ хамгийн түрүүнд арилжааны банканд ханддаг хэдий ч зээл олдохгүй байх, зээлийн шалгуурыг нь хангахгүй байх, зээл авсан ч шимтгэл, хураамж, хүүгийн хувь хэмжээ өндөр байдаг нь үйл ажиллагаанд нь тодорхой хэмжээний дарамт учруулдаг болохыг судалгаанд оролцогч ихэнх жижиг, дунд бизнес эрхлэгчид онцлон хэлж байсан юм. Тооцооллоор санхүүжилтийн орчны бүлгийн индекс  $-0.68$  гарсан нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд энэхүү орчин муу нөлөө үзүүлж байна гэж дүгнэжээ.

Судалгаанд оролцсон жижиг, дунд бизнес эрхлэгчдээс сүүлийн 12 сарын хугацаанд үйл ажиллагаагаа өргөжүүлэх, шинээр бизнес эрхлэхэд зориулж ямар нэг санхүүжилт авч байсан уу? гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 24.1% нь санхүүжилт авч байсан, 75.9% нь санхүүжилт авч байгаагүй гэж хариулсан байна.


Сүүлийн 1 жилд санхүүжилт авч байсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийг салбараар нь авч үзвэл үйлдвэрлэл хамгийн өндөр буюу 40.5% байгаа бол худалдаа 38.1%, үйлчилгээ 21.4% байна. Эндээс үзвэл үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд санхүүжилтийн хэрэгцээ худалдаа, үйлчилгээний салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдтэй харьцуулахад өндөр байдаг байна.

Зураг 2. Санхүүжилт авсан байдал, салбараар




Өнгөрсөн нэг жилийн хугацаанд санхүүжилтэд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дийлэнх нь буюу 76.2% нь банкны зээл болон 9.5% нь хөнгөлөлттэй зээл авч санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлжээ.

Зураг 3. Санхүүжилтийн эх үүсвэр




Өнгөрсөн нэг жилийн хугацаанд гаднаас санхүүжилт авсан 42 жижиг, дунд бизнес эрхлэгчид санхүүжилтийнхээ дийлэнх хэсгийг барилгаа өргөтгөх, сайжруулах (97.6%), эргэлтийн хөрөнгө худалдан авах (61.9%)-д зарцуулсан бөгөөд багахан хэсгийг өөр бизнес эрхлэх, бизнесээ өргөжүүлэх, судалгаа, шинжилгээ, машин тоног төхөөрөмжид зарцуулсан байна. Харин зар сурталчилгаа, ажилчдаа сургахад гаднаас авсан санхүүжилтээ огт зарцуулаагүй байна.

Зураг 4. Санхүүжилтийн зарцуулалт



Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 67.2% нь буюу 117 жижиг, дунд бизнес эрхлэгч сүүлийн нэг жилийн хугацаанд зээлээ хугацаанд нь төлж чадаагүй тохиолдол гаргаж байгаагүй бол 22.4% буюу 39 нь зээлээ хугацаанаас нь хэтрүүлэн төлж байжээ.

Зураг 5. Санхүүжилт авч чадаагүй шалтгаан



Сүүлийн 12 сарын хугацаанд ямар шалтгааны улмаас санхүүжилт авч чадаагүй вэ гэсэн асуултад түүвэр судалгаанд оролцсон нийт 174 жижиг, дунд бизнес эрхлэгчдээс 40 нь ямар нэг байдлаар хариулаагүй байна. Харин 134 нь хариулт өгсөн ба 59% нь өөрийн эх үүсвэрээр санхүүждэг бол 25.4% нь зээл авах нөхцөлийг хангасан боловч зээлийн нөхцөл хатуу байсан, 15.7% нь зээл авах нөхцөлийг хангаагүй гэж хариулжээ. Эндээс үзвэл жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүжилт олгодог гол байгууллага болох банкнууд зээлийн хүү өндөр бөгөөд зээлийн шалгуур хатуу байгаа нь шаардлагатай санхүүжилтээ авч үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг нэг том хүчин зүйл болдог байна.


Зураг 6. Санхүүжилт авч чадаагүй шалтгаан, салбараар



Санхүүжилт аваагүй шалтгааныг худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувьд 50-аас дээш хувь нь өөрийн эх үүсвэрээр санхүүждэг гэсэн бол худалдаа болон үйлдвэрлэлийн салбарын хувьд гаднын санхүүжилтийн


хэрэгцээ шаардлага үйлчилгээний салбараас илүү байна. Энэ нь үйлчилгээ эрхлэхэд худалдаа болон үйлдвэрлэл эрхлэхээс илүү бага хэмжээний санхүүжилт шаардлагатай байдагтай холбоотой байж болох юм.

Зураг 7. Зээл авах нөхцөл хатуу байсан шалтгаан



Зээл авч чадаагүй жижиг, дунд бизнес эрхлэгчдээс зээл авах нөхцөл хатуу байсан шалтгааныг тодруулахад дийлэнх нь зээлийн хүү өндөр (46.6%) гэж хариулсан бол бусад шалтгааныг судалгаанд оролцогчдын 13-20% нь зээл авахад хүндрэл учруулдаг хүчин зүйл гэж үзжээ. Эндээс үзвэл Орхон аймаг төдийгүй манай улсад банкны зээлийн хүү өндөр байдаг жижиг, дунд бизнес эрхлэгчдэд хүндрэл учруулдаг бөгөөд зээлийн нөхцөл хатуу байгаа хамгийн том шалтгаан нь зээлийн хүү гэж үздэг байна.


Зураг 8. Зээл авах шалгуур хангахгүй байхад нөлөөлсөн хүчин зүйлс



Зээл авах нөхцөлөө хангаагүй нийтлэг шалтгаан нь барьцаа хөрөнгө байхгүй, дутуу (39.4%), зээлийн мэдээлийн санд сөрөг бүртгэлтэй (12.9%), тогтмол орлогогүй (9.1%) байгаатай холбоотой байна.

Түүвэр судалгаанд хамрагдсан аж ахуйн нэгж, хувиараа бизнес эрхлэгчдийн 55.7% буюу 97 жижиг, дунд бизнес эрхлэгч ирэх нэг жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлэхэд нь санхүүжилт зайлшгүй хэрэгцээтэй байна гэж үзсэн байхад 44.3% нь санхүүжилт авах шаардлагагүй гэж үзжээ.


Зураг 9. Цаашид санхүүжилт авах хэрэгцээ, салбараар



Үйлдвэрлэл болон худалдааны салбарт үйл ажиллагаа эрхэлж буй жижиг, дунд бизнес эрхлэгчдэд цаашид санхүүжилт авах хэрэгцээ үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийнхээс харьцангуй их байна. Түүнчлэн жижиг, дунд бизнес эрхлэгчид ерөнхийдөө санхүүжилтийн хэрэгцээ шаардлага цаашид өндөр байхыг судалгааны үр дүнгээс харж болно.

Цаашид санхүүжилт авах зайлшгүй шаардлагатай байгаа гэж үзсэн 118 жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ихэнх нь банкнаас зээл авах (45.4%) болон хөнгөлөлттэй зээлд хамрагдах (36.4%) замаар санхүүжих хүсэлтэй байна.

Зураг 10. Санхүүжилт авахыг хүсэж буй эх үүсвэр




Харин борлуулагчаас зээлээр бараа бүтээгдэхүүн авах, гэр бүл найз нөхдөөс зээлэх, зах зээлд хувьцаа гаргах замаар санхүүжих төлөвлөгөөтэй



жигиг, дунд бизнес эрхлэгчид харьцангуй цөөн буюу дунджаар 1.7% орчим байна.

Өнгөрсөн хугацаанд жигиг, дунд бизнес эрхлэгчдийн 76.2% нь банкнаас зээл авч, 9.5% нь хөнгөлөлттэй зээлээр санхүүжилтийн эх үүсвэрээ шийдсэнээс харахад жигиг, дунд бизнес эрхлэгчид банкны зээлээс илүү хөнгөлөлттэй зээл авахыг хүсдэг ч хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг байна.

Зураг 11. Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ



Түүвэр судалгаанд хамрагдсан жигиг, дунд бизнес эрхлэгчдийн 34.9% нь 10 саяас 100 сая хүртэл, 30.5% нь 100 саяас дээш төгрөгийн санхүүжилт бизнесийн үйл ажиллагаа явуулахад нь шаардлагатай байна гэж хариулжээ.


Шаардлагатай санхүүжилтийн хугацааг үйл ажиллагаа эрхэлж буй хугацаагаар нь авч үзвэл 5 хүртэлх жил үйл ажиллагаа эрхэлж буй жигиг, дунд бизнес эрхлэгчдэд 50 хүртэлх сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай байдаг бол 6-аас дээш жил үйл ажиллагаа эрхэлж буй жигиг, дунд бизнес эрхлэгчдэд илүү их хэмжээний буюу 100 сая төгрөгөөс дээш дүнтэй санхүүжилт шаардлагатай байдаг байна.

Хүснэгт 1. Шаардлагатай санхүүжилтийн хэмжээ  
/бизнесийн насжилтаар/

	0-1 жил	2-5 жил	6-10 жил	11-ээс дээш
1.1-4.9 сая төгрөг	10.0%	10.0%	20.0%	60.0%
5.0-9.9 сая төгрөг	11.1%	16.7%	16.7%	55.6%
10.0-49.9 сая төгрөг	6.1%	36.4%	21.2%	36.4%
50.0-99.9 сая төгрөг	0.0%	25.0%	50.0%	25.0%
100.0-499.9 сая төгрөг	0.0%	10.5%	36.8%	52.6%
500 сая төгрөгөөс дээш	0.0%	20.0%	20.0%	60.0%
Мэдэхгүй	0.0%	100.0%	0.0%	0.0%


Хэрэгцээтэй байгаа санхүүжилтээ юунд зарцуулах вэ гэсэн асуултад судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 60.9% нь эргэлтийн хөрөнгө авахад зарцуулна гэж хариулснаас үзвэл жижиг, дунд бизнес эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгийн хэрэгцээ, шаардлага нэлээдгүй байдаг байна.

Зураг 12. Хэрэгцээтэй байгаа санхүүжилтээ зарцуулах чиглэл



Салбараар нь авч үзвэл худалдааны салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд эргэлтийн хөрөнгө нэлээдгүй хэрэгцээтэй болохыг судалгааны дүн харуулж байна.

Зураг 13. Шаардлагатай санхүүжилтийн хугацаа



Ирэх нэг жилийн хугацаанд санхүүжилт шаардлагатай байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 40% -д нь урт хугацааны санхүүжилт (5-аас дээш жилийн) шаардлагатай байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд шаардлагатай дундаж санхүүжилтийн хугацаа 3.8 жил байна.

## ДУГНЭЛТ

Судалгаанд Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумын 174 жижиг, дунд бизнес эрхлэгч хамрагдсанаас дийлэнх хувь нь тухайн бизнесийг удирдагч, эзэн, захирлууд оролцжээ. Судалгаанд оролцогчдын дийлэнх нь таваас дээш жил үйл ажиллагаа явуулсан туршлагатай, ихэвчлэн нэг төрлийн, дээд тал нь 5 хүртэл төрлийн бизнес эрхэлж байгаагаас худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд бизнес эрхлэгчид хамгийн өндөр хувийг эзэлж байна. Хуулийн этгээдийн хэлбэрээр авч үзвэл хоршоо болон хувиараа бизнес эрхлэгчдийн дийлэнх хувь нь 1 төрлийн бизнес эрхэлж байна. Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүжилтийн орчин нь хүндрэл учруулж байна.

Үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд санхүүжилтийн хэрэгцээ худалдаа, үйлчилгээний салбарын жижиг, дунд бизнес эрхлэгчдтэй харьцуулахад өндөр байдаг байна. Өнгөрсөн нэг жилийн хугацаанд санхүүжилтэд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дийлэнх нь буюу 76.2% нь банкны зээл болон 9.5% нь хөнгөлөлттэй зээл авч санхүүжилтийн эх үүсвэрээ бүрдүүлжээ.

Жижиг, дунд бизнес эрхлэгчид санхүүжилтийнхээ дийлэнх хэсгийг барилгаа өргөтгөх, сайжруулах, эргэлтийн хөрөнгө худалдан авахад зарцуулсан бөгөөд багахан хэсгийг өөр бизнес эрхлэх, бизнесээ өргөжүүлэх, судалгаа, шинжилгээ, машин тоног төхөөрөмжид зарцуулсан байна. Харин зар сурталчилгаа, ажилчдаа сургахад гаднаас авсан санхүүжилтээ огт зарцуулаагүй байна.

Судалгаанд хамрагдсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн 67.2% нь сүүлийн нэг жилийн хугацаанд зээлээ хугацаанд нь төлж чадаагүй тохиолдол гаргаж байгаагүй бол 22.4% нь зээлээ хугацаанаас нь хэтрүүлэн төлж байжээ.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд санхүүжилт олгодог гол байгууллага болох банкнууд зээлийн хүү өндөр бөгөөд зээлийн шалгуур хатуу байгаа нь шаардлагатай санхүүжилтээ авч үйл ажиллагаа явуулахад хүндрэл учруулдаг нэг том хүчин зүйл болдог байна. Зээл авах нөхцөлөө хангаагүй нийтлэг шалтгаан нь барьцаа хөрөнгө байхгүй, дутуу, зээлийн мэдээллийн санд сөрөг бүртгэлтэй, тогтмол орлогогүй байгаатай холбоотой байна.

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

International Trade Centre. (2020). *SME competitiveness outlook: COVID-19: The Great Lockdown and its Impact on Small Business*. Geneva.

International Trade Centre. (2021). *SME competitiveness outlook: Empowering the Green Recovery*. Geneva.

International Trade Centre. (2022). *SME competitiveness outlook: CConnected services, compepititive businesses* . Geneva.

International Trade Centre. (2023). *SME competitiveness outlook: Small Businesses in Fragility: From Survival to Growth*. Geneva.

OCED (2023) *SME and Entrepreneurship Outlook 2023*

Монгол банк. (2018). *Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжил, санхүүжилтийн байдал: Түцвэр судалгааны үр дүн*. Улаанбаатар хот.

Монгол банк. (2022). *Бизнесийн үйл ажиллагаа, санхүүжилтийн байдал: Түцвэр судалгаа 2021*. Улаанбаатар хот.

Нийслэлийн ЗДТГ, UNDP (2017). *Улаанбаатар хотын хөгжлийн санхүүжилтийн өнөөгийн байдал, санхүүжилтийн стратеги*. Улаанбаатар хот

Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төв (2022). *Улаанбаатар хотын ЖДҮҮ эрхлэгчдийн санхүүжилтийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох судалгааны ажил*. Улаанбаатар хот

USAID, BEST, Хөгжлийн шийдэл ТББ (2024) *Монгол улсын жижиг, дунд бизнесийн өрсөлдөх чадварын судалгаа*. Улаанбаатар хот

USAID, Хөгжлийн шийдэл ТББ, MEARC (2021) *Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварын судалгаа: Цар тахал, хөл хорио болон эдийн засгийн нөхцөлүцд бизнесийн орчинд нөлөөлөх нь*. Улаанбаатар хот

Дэлхийн банк (2022) *Монгол улсын бизнесийн орчин ба өрсөлдөх чадварын үнэлгээний тайлан: Эдийн засгийн сэргээхийн тулд бизнесийн орчны шинэчлэлийг хэрэгжүүлэх нь*. Улаанбаатар хот